

Асрахуйн эдийн засаг симпозиумын танилцуулга*

Maria S. Floro[†]

Elizabeth M. King[‡]

1. Асрахуйн эдийн засаг гэж юу вэ?

Энэхүү Асрахуйн эдийн засаг симпозиумд багтсан өгүүлэлд өрхүүдийн үзүүлдэг асрахуйн ажлыг илүү сайн ойлгох нь эдийн засаг хэрхэн ажилладаг, мөн аливаа олон нийтэд чиглэсэн бодлого, хөтөлбөрүүд хүссэн үр дүндээ хүрч чадаж байгаа эсэхийг илүү гүнзгий ойлгоход туслах юм. Асрахуйн эдийн засаг нь хүүхэд хооллох, хүүхдэд гэрийн даалгаварт нь туслах, хөгжлийн бэрхшээлтэй гэр бүлийн гишүүнд хувцаслахад туслах гэх мэт шууд халамж үзүүлэх үйл ажиллагаанаас эхлээд хоол хийх, хувцас угаах, ус авах гэх мэт шууд бие биетэйгээ харилцах шаардлагагүй шууд бус халамжийн үйл ажиллагаа зэрэг маш өргөн хүрээтэй үйл ажиллагааг хамардаг [ОУ-ын Хөдөлмөрийн Байгууллага, 2018:6]. Эдгээр үйл ажиллагааны ихэнхийг гэр бүлийн гишүүд эсвэл тусдаа амьдардаг хамаатнууд хийдэг. Мөн түүнчлэн, ашгийн болон ашгийн бус байгууллага, эсвэл ЗГ-ын харьяа халамж, үйлчилгээний байгууллагуудад ажилладаг цалинтай асрагчид гүйцэтгэдэг. Зарим тохиолдолд, ялангуяа бага насны хүүхдийг асрах зэрэг асрамжийн үйлчилгээг ажил олгогч нь эсвэл олон нийтийн байгууллагаас үзүүлж болдог.

Сүүлийн гучин жилийн хугацаанд асрахуйн үйл ажиллагааны эдийн засагт үзүүлэх стратегийн ач холбогдлыг илтгэсэн (Elson болон Cagatay [1995]; Дэлхийн Банк [2011]; Alonso болон бусад [2019]; Blecker болон Braunstein [2022]) судалгаанууд хэвлэгдэн гарсаар байна. Эдгээр судалгаанууд нь асрахуйн үйл ажиллагаа нь эдийн зас-

*Редакторын тэмдэглэл: Филиппиний эдийн засгийн тойм сэтгүүлийн зүгээс симпозиумыг зохион байгуулж, сэтгүүлд хэвлэгдэх илтгэлүүдийг хянасан Maria S. Floro болон Elizabeth M. King нарт талархал илэрхийлье.

[†]American University

[‡]The Brookings Institution

гийн өсөлт, тогтвортой хөгжилд хэрхэн чухал үүрэг гүйцэтгэдгийг харуулсан. Ийм үйл ажиллагаа нь улс орнуудын хүний болон нийгмийн капиталын үндэс суурийг бүрдүүлж, ажиллах хүчнийг хадгалахад тусалдаг. Цалинтай асрах үйлчилгээ, эсвэл нийгмийн эрүүл мэндийн үйлчилгээ хөгжөөгүй эсвэл хүртээмжгүй орчинд гэр бүлийн гишүүд, хамаатнууд, хөршүүд нь ийм үйлчилгээг гол үзүүлэгчид нь байдаг. Илүү хөгжингүй эдийн засагтай орнуудад асрах үйлчилгээний хувийн сектор илүү хөгжсөн байдаг ч, цалин хөлсгүй өрхийн асрах үйлчилгээ нь ач холбогдлоо хадгалааар байна. Эдгээр зүйлс ойлгомжтой мэт санагдаж болох ч, асрахуйн эдийн засаг, ялангуяа цалин хөлсгүй асрах үйлчилгээ нь бодлогын хэлэлцүүлгийн гадна үлддэг.

Үндэсний хөгжлийн төлөвлөгөө, бодлого боловсруулалтад асрахуйн үйл ажиллагаа байдаггүйн нэг шалтгаан нь эдгээр үйл ажиллагаа нь ихэнхдээ цалин хөлсгүй, арилжааны бус байдагт оршино. Дэлхийн олон улс орны “Цаг ашиглалтын судалгаа”-ны өгөгдлүүд хүмүүс өдөр тутамдаа ихэнх цагийг эдгээр үйл ажиллагаанд зориулдаг болохыг баталж байгаа хэдий ч, энэ нь Үндэсний Дансны Системд (System of National Accounts) ороогүй байна. НҮБ болон мэргэжилтнүүд цалин хөлсгүй асрахуйн үйлчилгээний салбарыг улс орнуудын үйлдвэрлэл, сайн сайхан байдлын хэмжүүрт оруулахыг оролдсон ч ахиц дэвшил хязгаарлагдмал байна. Тиймээс асрахуйн эдийн засагт оролцож буй хөдөлмөрийг тооцоолох нь тийм ч амар ажил биш юм. Асрахуйн эдийн засгийг харьцангуй үл тоомсорлосон бас нэг чухал шалтгаан нь энэхүү симпозиумын өгүүллүүдэд харуулсанчлан, дэлхий даяар асрахуйн ажил нь цалинтай эсвэл цалингүй байснаас үл хамааран ихэнхдээ охин, эмэгтэйчүүд хийдэг явдал юм. Эмэгтэйчүүдийн эдийн засагт оруулсан хувь нэмрийг хөгжлийн загвар болон өсөлтийн онолуудад үл тоомсорлож ирсэн.


Энэ симпозиумын өгүүллүүдэд нэгдүгээрт, асрахуйн эдийн засгийн цар хэмжээг үнэлэх, хоёрдугаарт, түүнийг макро эдийн засгийн загвар, эмпирик нотолгоо, үзүүлэлт зэрэг бодлогын арга хэрэгслүүдэд нэгтгэх зэрэг асуудлуудыг хөндсөн. Зохиогчид зах зээлийн эдийн засаг болон асрахуйн эдийн засгийн хоорондын харилцан хамаарлыг, мөн эдийн өсөлтийн үйл явцын богино болон урт хугацааны үр дагаврыг харуулахын тулд олон төрлийн онолын арга барил, эмпирик аргуудыг ашигласан. Мөн түүнчлэн Өмнөд Солонгос, АНУ зэрэг өндөр орлоготой орнуудаас гадна Колумб, Монгол, Турк зэрэг дунд орлоготой орнуудын жишээг дурдсан байна.

Өгүүллүүд нь нийтдээ асрахуйн асуудлууд нь Ази-Номхон далайн бүс нутгийг

оролцуулан дэлхий дахины хүн амын болон эдийн засаг, нийгмийн асуудлуудыг шийдвэрлэхэд гол үүрэг гүйцэтгэдгийг харуулж байна. Хүн амын өсөлт, насжилт, өрхийн бүтцийн өөрчлөлт, эдийн засгийн салбарууд болон ажил эрхлэлтийн хэв маягт гарсан өөрчлөлтүүд, мөн COVID-19 цар тахал гэх мэт дэлхий дахины хямралууд нь зөвхөн асрахуйн үйлчилгээний эрэлтэд нөлөөлөөд зогсохгүй эдгээр хэрэгцээг хангах одоогийн асрахуйн үйл ажиллагааны чадварт нөлөөлж байна. Энэхүү өгүүлүүдэд эдгээр тулгараад буй асрахуйн асуудлыг шийдвэрлэхэд боломжит бодлогын шийдэл болон засгийн газар, бизнесийн сектор, нийгэм болон хувь хүмүүсийн гүйцэтгэх чухал үүргийг онцолсон байна.

2. Асрахуй болон хүн ам зүйн шилжилт

1950, 2000, 2025 оны хүн амын насны суварга (НҮБ-ын дундаж тооцоог ашиглан) дэлхийн хүн амын насны бүтцэд, ялангуяа 1950-аас 2000 оны хооронд хагас зууны хугацаанд, чухал өөрчлөлт гарсныг харуулж байна (Зураг 1). Энэ хугацаанд төрөлтийн түвшин буурч, дундаж наслалт нэмэгдсэн. Үүний үр дүнд 15-аас доош насны хүн амын эзлэх хувь арван нэгж хувиар буурч (34.7 хувиас 24.5 хувь болж), 65 ба түүнээс дээш насны хүн амын эзлэх хувь хоёр дахин нэмэгдсэн (5.1 хувиас 10.5 хувь болсон). Төрөлтийн түвшин буурч, хүн амын суваргад дээрх өөрчлөлт гарсан ч гэлээ 0-14 насны хүүхдүүд дэлхийн хүн амын дөрөвний нэгийг бүрдүүлсээр байна. Энэ нь ялангуяа бага орлоготой орнуудад ажиглагдаж байгаа бол, өндөр орлоготой орнуудад ихэвчлэн хурдацтай насжилт/хөгшрөлт илүү их тохиолдож байна.



Зураг 1: Дэлхийн хүн амын тархалт, насны бүлгээр

Хүн амын насны тархалтын хоёр төгсгөлд байгаа бүлгүүд (хүүхдүүд болон хөгшид) нь асрахуйн асуудлын хэлэлцүүлгийн үндсэн сэдэв болдог. Таваас доош насны хүүхдүүдийг, тэр ч байтугай сургуулийн насны хүүхдүүдийг асран халамжлах нь өрхийн цаг зав, хүч чадал, нөөц боломжийн ихээхэн хэсгийг шаарддаг байна. Жишээ нь, Өмнөд Солонгост асрамжийн хэрэгцээтэй өрхийн гишүүд нь хүүхэд, өндөр настныг асран халамжлахад долоо хоногт дунджаар 50 цагаас илүү цаг зарцуулдаг байна [Cha нар. 2023]. АНУ-д өндөр настнуудыг асран халамжилдаг хүмүүсийн ихэнх нь өөрсдөө ажил хөдөлмөр эрхэлдэг хүмүүс байдаг байна [Ahmed болон Flogo энэ дугаарт].

Нийтийн эрүүл мэндийн салбарт гарсан дэвшил нь өндөр настнуудыг илүү эрүүл байлгахад хувь нэмэр оруулсан ч, дундаж наслалт нэмэгдэхийн хэрээр 80 ба түүнээс дээш насны хүмүүсийн эзлэх хувь нэмэгдэж, энэ нь өрхийн асрах ажил, эрүүл мэндийн болон цалинтай асрах үйлчилгээний эрэлтийг нэмэгдүүлж байна (Хүснэгт 1).

Хүснэгт 1: Дэлхийн хүн амын тархалт, насны бүлгээр			
Хувь	1950	2000	2025
5-аас доош настай	13.7	8.7	7.9
15-аас доош насныхан	34.7	25.7	24.5
65 ба түүнээс дээш нас	5.1	9.4	10.5
80 ба түүнээс дээш нас	0.6	1.9	2.1
Эх сурвалж: НҮБ-ын хүн амын үзүүлэлт (дунд хувилбар)			

Эдгээр хүн амын насны бүтцийн өөрчлөлтүүд нь хүүхэд болон өндөр настнуудад зориулсан асрамж үйлчилгээний эрэлтийг нэмэгдүүлж, одоо байгаа асрамж үйлчилгээний тогтолцоог сорилтод оруулж, олон өрхүүдийг дарамтад оруулж байна. “Сэндвич үеийнхэн” гэж нэрлэгддэг насанд хүрэгчид буюу бага насны хүүхдүүдээ болон өндөр настай эцэг эхээ асран халамжилдаг хүмүүс бодит асуудалтай тулгарч байна. Эдгээр асран халамжлагчдаас авсан судалгаагаар тэд санхүүгийн хүндрэлтэй тулгарч, бусад халамж үзүүлэгчдээс хоёр дахин их санхүүгийн бэрхшээл, мөн 50 хувиар илүү сэтгэлзүйн дарамтад өртдөг байна [Lei нар. 2023]. Хүн амын энэхүү өөрчлөлтүүдтэй хамт хурдацтай хотжилт, цагаачлалын өндөр түвшин зэрэг эдийн засгийн үзэгдлүүд нь олон оронд өрхийн бүтэц болон гэрлэлтийн хэв маягт өөрчлөлт авчирсан. Эдгээр өөрчлөлтүүдийн нэг үр дүн нь олон хүүхдүүд эцэг эхийнхээ аль нэгтэй,

эсвэл эцэг эхгүй өсөж байгаа явдал юм. Өрх толгойлсон ганц бие эцэг/ эх нь санхүүгийн хувьд хамгийн эмзэг бүлгүүдийн нэг бөгөөд тэдгээрийн ихэнх нь хамаатан садан эсвэл хөлстэй асрах үйлчилгээнээс тусламж авах боломжгүй байдаг.

3. Асрахуйн эдийн засгийн үндсэн асуудлууд

Өнөөгийн байдлаар, мөн ирээдүйд ч гэсэн өрх доторх асрах ажлын хамгийн хүнд ачааг эмэгтэйчүүд үүрэх магадлалтай байгаа тул [King нар. 2021] тэдний цалингүй асрах ажил болон хөдөлмөрийн зах зээлд оролцох хоёрын хоорондын хурцадмал байдал нь сүүлийн үеийн судалгааны гол сэдэв болж байна (Дэлхийн Банк [2011, 2021]; Ferrant нар. [2014]; Beneria нар. [2016]; Connolly болон Kongar [2017]; Blau болон Winkler [2017]; Charmes [2019]; Alonso нар. [2019]). Эмпирик судалгаанууд нь гэрийн ажил болон хүүхэд халах үүрэг нь соёл, нийгмийн хэм хэмжээний нөлөөгөөр эмэгтэйчүүдийн хөдөлмөрийн зах зээлд оролцох оролцоог хязгаарлаж, тэдний амьжиргаанд нөлөөлдөг болохыг харуулж байна. Дэлхий даяар эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин ердөө 50 орчим хувь байхад, эрэгтэйчүүдийнх 80 хувьд хүрсэн бөгөөд энэхүү хэмжээ сүүлийн гучин жилийн хугацаанд бараг өөрчлөгдөөгүй байна [Дэлхийн Банк 2023a]. Асрахуйн үйл ажиллагаа, гэрийн ажил, эмэгтэйчүүдийн зах зээлд оролцох оролцоо хоорондын харилцаа нь энэхүү симпозиумын нэлээд хэдэн өгүүлүүдийн гол сэдэв болж байна.

Өмнөд Солонгос, Колумб зэрэг олон улс орон хүйсийн тэгш байдлын чиглэлээр олон талаар ахиц гаргасан хэдий ч, өрх доторх цалингүй асрах ажлын ачаалал болон хуваарилалтын тэгш бус байдал хэвээрээ байна. Martin Cicowiez, Hans Lofgren, Ana Tribin болон Tatiana Mojica нар Өмнөд Солонгос болон Колумбын эдийн засгийн бодлогуудыг судалж, эмэгтэйчүүдэд илүү сайн цалинтай ажил хийх боломж олгох замаар асрах үүрэг бүхий өрхүүдийн сайн сайхан байдлыг сайжруулах боломжийг судалсан. Тэд эдгээр хоёр орны эдийн засгийн асрах үйлчилгээг төвлөрүүлсэн, хүйсийн асуудлыг анхаарч үзсэн ерөнхий тэнцвэрийн (CGE) загваруудыг боловсруулж, шинэ арга барилыг нэвтрүүлсэн. CGE загварууд нь эдийн засгийн бодлогын боломжит нөлөөллийг шинжлэхэд түгээмэл хэрэглэгддэг хэрэгсэл боловч, асрахуйн үйл ажиллагааны макро нөлөөллийг судлахад ховор хэрэглэгддэг байна. Өмнөд Солонгос болон Колумбын хүйсийн асуудлыг анхаарч үзсэн CGE загварууд буюу GEM-Care загварууд нь асрах үйлчилгээг эдийн засгийн орц болгон тусгаж, ажиллах хүчний хэмжээнд шууд нөлөөлөх, цалин, өрхийн орлого, хэрэглээнд шууд бус нөлөө үзүүлдэг.

Эдгээр загварууд нь нийтийн асрах үйлчилгээг өргөжүүлэх, өрх болон хувийн секторын асрах үйлчилгээг дэмжих, ажиллах хүчний оролцоо болон цалингийн хүйсийн ялгааг багасгах, эдийн өсөлт, гэр бүлийн сайн сайхан байдлыг дэмжих бодлогуудын нөлөөллийг урьдчилан таамаглахад ашиглагддаг. Колумбын тухай өгүүлэлд, хүүхэдтэй гэр бүлд мөнгөн тэтгэмж олгох нь хувийн хэрэглээ, цалингүй асрах ажил, эмэгтэйчүүдийн хөдөлмөрийн нийлүүлэлт, эдийн өсөлтөд хэрхэн нөлөөлдөг талаар судалсан байна. Эдгээр бодлогын үр нөлөө нь өрхийн болон эдийн засгийн хүрээнд хүйсийн үүргийн уян хатан байдал, хөдөлмөрийн хуваарилалтаас шалтгаална гэж дүгнэсэн байна.

Энэ симпозиумд İpek İkkaracan болон Emel Memiş нарын бичсэн өгүүлэл нь Турк улсад COVID-19 халдварын үед үүссэн янз бүрийн уян хатан ажлын хэв маяг нь өрх дэх эрэгтэй, эмэгтэйчүүдийн зах зээлийн болон цалингүй асрах ажлын цагийн хуваарилалтыг хэрхэн өөрчилснийг харуулсан. Тэд цар тахлын өмнө болон цар тахлын үеэр хийсэн гурван судалгааны өгөгдлийг ашиглан хөл хорионы үед болон дараа, хөл хориог сулруулсны дараа цалинтай ажил болон цалингүй асрах ажлын цагийн хуваарилалт хэрхэн өөрчлөгдсөнийг тогтоожээ. Зарим ажлын хязгаарлалтыг хөнгөлсний дараа эмэгтэй, эрэгтэйчүүдийн цалингүй ажлын цаг цар тахлын өмнөх үеэс илүү өндөр хэвээр байсан ч, хөл хорионы үеэс бага байв. Гэсэн хэдий ч хөдөлмөрийн зах зээлд зарцуулж буй цаг цар тахлын өмнөх түвшинд эргэн ирсэн бөгөөд ажилтай эрэгтэйчүүдийн хувьд цар тахлын өмнөхөөс арай өндөр түвшинд хүрсэн. Гэхдээ ажлын цаг хаана тогтох нь хэлэхэд эрт байна. Үүнээс гадна хөл хорионы арга хэмжээг хөнгөлсний дараа ажлын байр нь ажлын газар руу буцаж ирсэн ч, зарим нь цахим болон холимог ажлын хэв маягийг хадгалсан, ялангуяа эмэгтэйчүүдийн хувьд. Энэхүү өгүүлэл нь ажлын хэв маягийн хурдацтай өөрчлөлтөөс үүдэлтэй эмэгтэй, эрэгтэйчүүдийн хөдөлмөрийн нийлүүлэлтийн зан төлөвийн өөрчлөлтийг судлах боломжтой байгаагаараа харьцангуй өвөрмөц байна. Өрх доторх цагийн хуваарилалтыг ойлгох нь ажиллах хүчний оролцоо зэрэг эдийн засгийн үзүүлэлтүүдээр өрх, нийгмийн тусламж үйлчилгээний хөтөлбөрийн нөлөөллийг урьдчилан таамаглахад тусалдаг. Өрх дотор цалингүй асрах ажлыг хэн хийдэг нь эдийн засаг, бодлогын хувьд чухал ач холбогдолтой. Энэ симпозиум дахь Elizabeth King, Hannah Randolph болон Jooyeoun Suh нарын өгүүлэл нь хүүхэд асрах, гэрийн ажил, хөдөлмөрийн зах зээлд цалинтай ажил эрхлэх гэх мэт үйл ажиллагааг гэр бүлийн гишүүд хэрхэн ху-

ваалцдаг, эмэгтэй, эрэгтэйчүүд эдгээр үйл ажиллагаанд хэрхэн оролцдог талаар судалсан. Зохиогчид Монгол болон Өмнөд Солонгосын “Цаг ашиглалтын судалгаа”-ны өгөгдлийг ашиглан дээрх асуултуудад хариулсан. Эдгээр хоёр улс нь эдийн засгийн хөгжлийн түвшин, аж үйлдвэрийн бүтэц, хүн амын бүтэц, өрхийн бүтэц зэргээрээ ялгаатай байгаа нь өрх доторх цагийн хуваарилалтыг харьцуулах боломжийг олгож байна. Уламжлалт үзэл бодол, нийгмийн хэм хэмжээ, түүнчлэн цалин хөлстэй асрах үйлчилгээний зах зээл нь эдгээр хуваарилалтын шийдвэрт чухал нөлөө үзүүлдэг ч, эдгээр нийгмийн хүчин зүйлс нь өөрсдөө хүн амын болон эдийн засгийн өөрчлөлтөд хариу үйлдэл үзүүлж байна. Tanima Ahmed болон Maria Floro нарын өгүүлэл нь дундаж наслалт, хамааралтай байдлын харьцаа нэмэгдэж байгаагаар холбогдуулан өндөр настнуудад үзүүлэх халамжийн асуудлыг, ялангуяа АНУ-д, онцолж байна. Бага, дунд орлоготой орнуудтай ижил, өндөр орлоготой орнуудаас ялгаатай нь АНУ-д эмзэг бүлгийн өндөр настнуудын ихэнх нь цалингүй асран халамжлагчдаас ихээхэн хамаардаг. Энэ нь урт хугацааны асрах үйлчилгээнд зориулсан хөрөнгө оруулалтыг хангалтгүй төлөвлөсөнтэй холбоотой юм. Америкийн “Цаг ашиглалтын судалгаа”-ны өгөгдлийг ашиглан зохиогчид өдөр бүр эсвэл долоо хоногт хэд хэдэн удаа өндөр настан асрах нь эмэгтэй, эрэгтэйчүүдийн хөдөлмөрийн зах зээлд оролцох хувийг есөн хувиар бууруулдаг болохыг харуулсан. Цалин хөлсгүйгээр өндөр настнуудыг асрах болон цалинтай ажил эрхлэх хоорондын солилцоо нь асрах үйлчилгээ болон өрхийн чөлөөт цагийн бодлогод нийтийн хөрөнгө оруулалт хангалтгүй хийгдсэнээс үүдэлтэй хязгаарлалтыг тодотгож байна.

Цалинтай асрах үйлчилгээ нь өрх дэх цалин хөлсгүй асрах ажлын ихэнх хэсгийг орлож, улмаар өрхийн ачааллыг хөнгөлж, бусад эдийн засгийн үйл ажиллагаанд цаг зарцуулах боломжийг олгох уу? Асрах үйлчилгээний эрэлт нэмэгдэж байгаагаар холбогдуулан дунд болон өндөр орлоготой орнуудын засгийн газрууд олон төрлийн бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Үүний нэг нь хүүхэд асрах, бага насны хүүхдийн боловсрол, нийгмийн янз бүрийн бүлгүүдэд суурилсан цэцэрлэг, асрамж хэрэгтэй өндөр настнуудад зориулсан урт хугацааны асрах үйлчилгээг өргөжүүлэх юм. Shirin Arslan болон түүний хамтран зохиогчдын өгүүлэл нь ийм үйлчилгээг илүү өргөн ашиглахад саад болдог гол шалтгаануудын нэг болох цалинтай асрах үйлчилгээний чанарын талаарх асуудлыг шийдвэрлэхийг зорьсон. Асрах үйлчилгээ нь бусад төрлийн үйлчилгээнээс ялгаатай нь тасралтгүй хувийн анхаарал шаарддаг. Зарим

хүмүүсийн үзэж байгаагаар хайртай гэр бүлийн гишүүн эсвэл хамаатнуудын үзүүлж чадах халамж, сэтгэл зүйн дэмжлэгийг орлож чадахгүй гэж үздэг бол, зарим нь цалинтай асрагчид мэргэжлийн сургалтад хамрагдсан тул жишээ нь, сэтгэцийн өвчтэй өндөр настанд шаардлагатай төрлийн асрах үйлчилгээг илүү сайн үзүүлж чадна гэж үздэг. Асрах үйлчилгээ үзүүлдэг ажилтнуудын хариуцлагын мэдрэмжид нөлөөлдөг хүчин зүйлс, тухайлбал ажлын нөхцөл (ажлын аюулгүй байдал, ажлын хуваарийн урьдчилсан мэдээлэл, сургалтын хангалттай байдал) зэргийг судалснаар энэхүү өгүүлэл нь асрахуйн бодлого, хөтөлбөрүүдийн чухал хэмжээсүүдийг тодруулж, илүү их анхаарал хандуулах ёстойг онцолсон.

4. Филиппиний эдийн засаг дахь асрахуй

Филиппинд асрахуйн эдийн засгийн асуудлууд хэр чухал вэ? Дэлхийн бусад орнуудын адил сүүлийн хорин жилийн хугацаанд Филиппиний хүн амын бүтэц мэдэгдэхүйц өөрчлөгдсөн. Тухайлбал, 1960 онд Төрөлтийн тусгай коэффициент 7.1 байсан бол 2021 онд 2.7 болж буурч, мөн дундаж наслалт 1960 оноос 2021 оны хооронд 59.2-оос 69.3 болж нэмэгдсэн [Дэлхийн банк 2023a]. Сүүлийн хэдэн арван жилийн турш хүн амын бүтцийн энэхүү өөрчлөлт болон хөдөө орон нутгаас хот руу чиглэсэн болон олон улсын цагаачлалын томоохон урсгал нь улс орны асрахуйн эдийн засгийг төлөвшсөн хамаатан садны холбоо, өрхийн бүтцэд ихээхэн өөрчлөлт авчирсан юм. Тухайлбал, эцэг эх нь удаан хугацаагаар эзгүй байгаагаас эцэг эхгүй эсвэл өрх толгойлсон ганц бие эцэг/эх-тэй өрх олширч, арсан халамжлах дэмжлэг үзүүлэх ойр дотно хүмүүс цөөрсөн байна. 2018 оны Филиппиний Шилжих хөдөлгөөний Үндэсний Судалгаагаар өрхүүдийн 12 хувь нь хилийн чанадад ажилладаг Филиппин ажилчинтай (Overseas Filipino Worker - OFW) эсвэл ажилладаг байсан гишүүнтэй өрх байна [Үндэсний Статистикийн Газар 2023]. Хилийн чанадад Филиппин ажилчид үйлдвэрийн ажилчин, гэрийн үйлчлэгчээс эхлээд инженер, сувилагч гэх мэт ажил хийхээр гэр бүлээсээ холдож, ард үлдсэн гэр бүлдээ санхүүгийн туслалцаа үзүүлэх орлого олж байна. Тэдний 2017 онд илгээсэн мөнгөн шилжүүлэг нийт 32.8 тэрбум ам.долларт хүрч, улсын ДНБ-ий 10 хувийг бүрдүүлсэн [Дэлхийн банк 2023b]. Энэхүү томоохон цагаачлалын урсгал нь хүүхдүүдийг өсөж хөгжих эхэн үед нь эцэг эхээс нь тусгаарлаж, хүүхдүүдийн эрүүл хөгжилд сөргөөр нөлөөлж байна. Эцэг эхээсээ хол тусдаа амьдардаг хүүхдүүдийн судалгаагаар эдгээр хүүхдүүд эрүүл мэндийн (ерөнхий эрүүл мэнд, ариун цэвэр, өвчин, хоол тэжээл) болон сэтгэл зүйн (зан ааш, оюун

ухаан, сэтгэл хөдлөл) асуудлуудтай тулгардаг болохыг тогтоожээ [Dominguez болон Hall 2022]. Өрх, хүүхэд, өндөр настнуудад үзүүлэх цагаачлалын асуудлаас үүдэлтэй дээрх дарамтыг бодлогын шийдвэр гаргагчид илүү их анхаарах шаардлагатай. 2018 онд 0-4 насны хүүхдүүдийн 10 хүрэхгүй хувь нь нийтийн бага насны хүүхдийн асрамж, хөгжлийн хөтөлбөрт хамрагдаж байсан. Хэдийгээр томоохон хотуудад хувийн секторын хүүхэд асрах үйлчилгээ байдаг ч, тэдгээр нь бага орлоготой гэр бүлүүдэд хүртээмжгүй байдаг [Epetia 2019]. Асрамж үйлчилгээний хүртээмж, чанарын талаарх асуудлууд нь асрахуйн хэрэгцээгээ хангахын тулд гаднаас тусламж эрэлхийлж буй өрхүүдэд саад болж байна. Сүүлийн 60 жилийн хугацаанд эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны өссөн ч эмэгтэйчүүд өрх доторх гол асрах үйлчилгээг үзүүлэгч гэсэн нийгмийн хүлээлт хэвээрээ байсаар байна. Олон улсын нийгмийн судалгааны хөтөлбөрийн "Дэлхийн үнэ цэн ба хүйсийн үүрэг" судалгаагаар Филиппинчүүдийн 80 гаруй хувь нь эрэгтэйчүүдийн үүрэг бол мөнгө олох, харин эмэгтэйчүүдийн үүрэг бол гэр орноо хариуцах гэдэгтэй санал нийлж, бараг тал хувь нь ажил хөдөлмөр эрхэлдэг ээжтэй сургуулийн өмнөх насны хүүхэд тодорхой хэмжээгээр хохирдог гэдэгтэй санал нэгдсэн байна [Дэлхийн Банк 2021]. Хүйсийн уламжлалт хэм хэмжээ болон бүх талыг хамарсан асрамжийн бодлогын дутагдалтай байдалтай холбоотойгоор ажил хөдөлмөр эрхэлдэг эмэгтэйчүүдийн цалин хөлстэй ажлын болон цалин хөлсгүй гэрийн ажил, асрах ажлын цагийг нэгтгэвэл ажил хөдөлмөр эрхэлдэг эрэгтэйчүүдийнхээс дунджаар илүү цаг ажилладаг байна [Abrigo болон Francisco-Abrigo 2019]. Энэ сургамж нь эмэгтэйчүүдийг орлого олох ажилд оролцоход нь саад болох биш, харин тэдэнд тулгардаг саад бэрхшээлийг шийдвэрлэхэд анхаарах явдал юм. Эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоо өндөр байх нь эдийн засгийн өсөлт болон хүйсийн тэгш байдалд чухал үүрэг гүйцэтгэдэг [Philippine Institute of Development Studies 2022]. Судалгаагаар, эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоо 2020 онд 45 хувийн суурийн түвшнөөс жилд дунджаар 0.5 нэгж хувиар өсвөл 2021-2050 онд ДНБ болон нэг хүнд ногдох ДНБ жилд дунджаар 0.3 нэгж хувиар өсөх хандлагатай байна [Дэлхийн Банк 2021]. Асрахуйн дэмжлэг үзүүлэх бодлогын дутагдалтай байдал нь нь бага орлоготой, эмзэг өрхүүдэд хамгийн их хохирол учруулдаг учраас үндэсний бүх талыг хамарсан асрахуйн бодлого нь эдийн засгийн өсөлт болон ядуурлыг бууруулах бодлого байх болно.

5. Асрахуйн эдийн засгийн талаарх судалгааны уриалга

Энэ симпозиумын судалгаанууд нь улс орнуудын өөр өөр нөхцөл байдалд асрахуйн эдийн засгийг ойлгоход шаардлагатай зарим төрлийн судалгааг харуулж байна. Цаг ашиглалтын судалгаа, асрахуйн хэрэгцээ, зохицуулалттай холбоотой асуулт бүхий өрхөд суурилсан судалгаа, ажиллах хүчний судалгаа, цалин хөлсгүй асрах ажиллагсдын судалгаа гэх зэрэг олон төрлийн судалгааны өгөгдлийг ашигласан эдгээр судалгаанууд нь асрахуйн эдийн засгийн талаарх мэдлэгийг өргөжүүлэх боломжийг харуулж байна. Үүнээс гадна ажиллах хүчний судалгаанд хангалтгүй тусгагдсан, ихэнхдээ өрхийн гишүүд эсвэл цалин хөлстэй гэрийн ажилтнуудаар гүйцэтгэгддэг асрахуйн үйл ажиллагааны хэмжүүрийг илүү сайжруулах хэрэгтэйг харуулж байна. Асрах үйлчилгээ нь мөн чанараараа хувь хүний үйл ажиллагаа учраас хүмүүсийн асрахуйн талаарх итгэл үнэмшил, эрхэмлэдэг зүйлс болон гэр бүл, нийгэм хамт олны доторх болон тэдний хоорондын асрахуйтай холбоотой харилцааны талаарх нотолгоо нь асрахуйн эдийн засгийн судалгааг баяжуулах болно. Хүн амын, технологийн, эдийн засгийн өөрчлөлтүүд, түүнчлэн COVID-19 цар тахал гэх мэт урьдчилан таамаглаагүй гэнэтийн үзэгдлүүдээс шалтгаалан асрахуйн үйл ажиллагааны мөн чанар, түүнд оролцогч хүмүүс цаг хугацааны явцад өөрчлөгддөг. Panel судалгаа болон давталттай cross-section судалгааны өгөгдлийг ашиглах нь эдгээр өөрчлөлтүүдийн хэмжээ, чиглэлийг хянах боломжийг олгоно. Эцэст нь судалгаа нь асрахуйн эдийн засгийг илүү харагдахуйц, илүү сайн ойлгогдохоор болгохоос гадна микро болон макро эдийн засгийн загвар болон бусад бодлогын хэрэгслүүдэд нэгтгэх замаар нийгмийн болон эдийн засгийн бодлогын үр нөлөөг сайжруулахад тусална.

Ашигласан ном

- [1] Abrigo, M. and K. Francisco-Abrigo [2019] “Counting women’s work in the Philippines”, PIDS Discussion Paper Series No. 2019-02.
- [2] Alampay, L.P. [2014] “Parenting in the Philippines”, in H. Selin (ed.) Parenting across cultures. Science across cultures: the history of non-western science, 7:105-121. Dordrecht: Springer. https://doi.org/10.1007/978-94-007-7503-9_9
- [3] Alonso, C., M. Brussevich, M. Dabla-Norris, Y. Kinoshita, and M.K. Kochhar [2019] “Reducing and redistributing unpaid work: stronger policies to support gender

- equality”, IMF Working Paper 19/222. Washington DC: International Monetary Fund.
- [4] Beneria, L., G. Berik, and M.S. Floro [2016] “Paid and unpaid work: meanings and debates”, in L. Beneria, G. Berik, and M.S. Floro (eds.) *Gender, development and globalization: economics as if all people mattered*: 179-226. New York: Routledge.
 - [5] Blau, F. and A. Winkler [2017] “Women, work, and family”, National Bureau of Economic Research Working Paper No. w23644. <https://www.nber.org/papers/w23644>
 - [6] Blecker, R. and E. Braunstein [2022] “Feminist perspectives on care and macroeconomic modeling: introduction to the special issue”, *Feminist Economics* 28(3):1-22.
 - [7] Cha, S.-E., E. Kang, M. Floro, S. Arslan, and A. Alam [2023] “When caregiving becomes burden: the gap between preferred amount of care time and actual amount of care time”, *Social Indicators Research*, forthcoming.
 - [8] Charmes, J. [2019] *The unpaid care work and the labour market: an analysis of time use data based on the latest world compilation of time-use surveys*. Geneva: International Labour Office.
 - [9] Connelly, R. and E. Kongar (eds.) [2017] *Gender and time use in a global context: the economics of employment and unpaid labor*. New York: Palgrave MacMillan
 - [10] Dominguez, G.B. and B.J. Hall [2022] “The health status and related interventions for children left behind due to parental migration in the Philippines: a scoping review”, *The Lancet Regional Health-Western Pacific* 28 (November):100566.
 - [11] Elson, D. and N. Cagatay [2000] “The social content of macroeconomic policies”, *World Development* 28(7):1347-1364.
 - [12] Epetia, M.C. [2019] “Explaining the gender gap in labor force participation in the Philippines”, *Japan Labor Issues* 3(7):30-38.
 - [13] Ferrant, G., L.M. Pesando, and K. Nowacka [2014] “Unpaid care work: the missing link in the analysis of gender gaps in labour outcomes”, *Boulogne Billancourt*:

Organization of Economic Cooperation and Development (OECD) Development Center.

- [14] King, E., H. Randolph, M.S. Floro, and J. Suh [2021] “Demographic, health, and economic transitions and the future care burden”, *World Development* 140(C):105371.
- [15] International Labour Organization (ILO) [2018] *Care work and care jobs for the future of decent work*. Geneva.
- [16] Lei, L., A.N. Leggett, and D.T. Maust [2023] “A national profile of sandwich generation caregivers providing care to both older adults and children”, *Journal of the American Geriatrics Society* 71(3):799-809.
- [17] National Statistics Authority [2023] “National migration survey”, <https://psa.gov.ph/tags/national-migration-survey>. Accessed June 2023.
- [18] Philippine Institute for Development Studies [2022] “Women in the workplace paving a better landscape in the labor force”, <https://www.pids.gov.ph/details/news/in-the-news/women-in-the-workplace-paving-a-better-landscape-in-the-labor-force>. Accessed June 2023.
- [19] World Bank [2011] *World development report 2012: Gender equality and development*. World Bank.
- [20] World Bank [2021] *Overcoming barriers to women’s economic empowerment in the Philippines*. Washington, DC: World Bank.
- [21] World Bank [2023a] *World development indicators*. <https://databank.worldbank.org/source/world-development-indicators>. Accessed June 2023.
- [22] World Bank [2023b] “Data on remittances”, <https://www.knomad.org/data/remittances>. Accessed June 2023.